БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2026/061/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2026 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Х.Женисбек<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Ж.Назгүл<br>Утас: 99998909 Цахим хаяг: nazgulj @audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 3

.......... 3

.......... 4

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 5

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 11

**3.1 Төлбөрийн акт** .......... 11

**3.2 Албан шаардлага** .......... 11

**3.3 Зөвлөмж** .......... 11

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 12


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ТТӨХ | Тоног төхөөрөмж |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2026.02.28 № 275

танай_____________-ны №_____________-т

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.ЕРКЕГҮЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь 2025 онд 6,033.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 5,690.9 сая төгрөг зарцуулж, 94.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

832605000368

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЖЕНИСЫЕК

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **480,196,042.04** | **273,158,737.86** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 333,719,181.00 | 209,932,553.14 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 333,719,181.00 | 209,932,553.14 |
| **3121** | **Төгрөг** | 333,719,181.00 | 209,932,553.14 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 333,719,181.00 | 209,932,553.14 |
| **33** | **АВЛАГА** | 82,421,445.32 | - |
| **335** | **Бусад авлага** | 82,421,445.32 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 68,170,745.32 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 14,250,700.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 64,055,415.72 | 63,226,184.72 |
| **354** | **Хангамжийн материал** | 64,055,415.72 | 63,226,184.72 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,039,910.00 | 1,189,510.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,967,060.00 | 770,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 57,048,445.72 | 61,266,674.72 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,883,358,321.50** | **4,925,565,118.47** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,883,358,321.50 | 4,925,565,118.47 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,764,631,730.30 | 4,807,123,175.07 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,680,276,106.14 | 4,730,276,106.14 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (477,460,604.20) | (504,128,341.84) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 716,771,574.00 | 763,971,385.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (326,106,992.23) | (416,510,711.15) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 260,064,420.60 | 268,331,769.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (174,164,358.01) | (165,219,017.68) |
| 39217 | Ном | 85,251,584.00 | 130,401,985.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 118,726,591.20 | 118,441,943.40 |
| 39301 | Програм хангамж | 1,973,239.00 | 1,973,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (834,647.80) | (1,119,295.60) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 117,588,000.00 | 117,588,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,363,554,363.54** | **5,198,723,856.33** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **14,250,700.00** | **52,474,408.50** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 14,250,700.00 | 52,474,408.50 |
| **413** | **Өглөг** | 14,250,700.00 | 52,474,408.50 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 45,000,908.50 |
| **4136** | **Бусад өглөг** | 14,250,700.00 | 7,473,500.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 14,250,700.00 | 7,473,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,349,303,663.54** | **5,146,249,447.83** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,349,303,663.54 | 5,146,249,447.83 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 842,334,698.00 | 842,334,698.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 842,334,698.00 | 842,334,698.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 982,104,408.65 | 781,345,578.94 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 982,104,408.65 | 984,399,794.65 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (203,054,215.71) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,524,864,556.89 | 3,522,569,170.89 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,363,554,363.54** | **5,198,723,856.33** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,712,444,945.12** | **6,092,696,830.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **419,161,845.12** | **403,791,230.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 419,161,845.12 | 403,791,230.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 36,453,400.00 | 403,791,230.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 36,453,400.00 | 2,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 399,494,001.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 2,297,229.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,293,283,100.00** | **5,688,905,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,207,730,100.00 | 5,591,835,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,207,730,100.00 | 5,591,835,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 85,553,000.00 | 97,070,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 85,553,000.00 | 97,070,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,423,193,746.40** | **6,086,663,045.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,423,193,746.40** | **6,086,663,045.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,156,302,146.40 | 5,693,638,445.71 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,092,812,056.00 | 4,590,967,172.98 |
| 210101 | Үндсэн цалин | 2,824,755,182.00 | 2,894,725,239.63 |
| 210102 | Нэмэгдэл | 1,040,782,791.00 | 1,548,370,389.35 |
| 210104 | Урамшуулал | 227,274,083.00 | 147,871,544.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 512,483,573.68 | 571,573,680.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 351,132,163.00 | 388,670,103.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 40,747,857.00 | 45,725,894.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 20,544,629.68 | 22,862,947.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 19,441,496.00 | 22,862,947.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 80,617,428.00 | 91,451,789.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 83,849,750.00 | 94,888,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,036,000.00 | 25,081,370.00 |
| 210302 | Түлш, халаалт | 61,313,750.00 | 64,470,324.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 5,336,306.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 2,931,100.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 2,931,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 91,837,552.00 | 85,069,629.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,453,400.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 56,384,152.00 | 85,069,629.86 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 375,319,214.72 | 348,208,862.03 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 76,248,270.00 | 107,705,228.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 103,581,746.00 | 23,449,430.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 195,489,198.72 | 217,054,204.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 266,891,600.00 | 393,024,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 266,891,600.00 | 393,024,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 266,891,600.00 | 393,024,600.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **289,251,198.72** | **6,033,784.29** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 209,088,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 209,088,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (209,088,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **289,251,198.72** | **(203,054,215.71)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **5,315,485,800.00** | **5,690,905,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,202,700.00** | **2,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,202,700.00 | 2,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 22,202,700.00 | 2,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,202,700.00 | 2,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,293,283,100.00** | **5,688,905,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,207,730,100.00 | 5,591,835,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,207,730,100.00 | 5,591,835,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 85,553,000.00 | 97,070,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 85,553,000.00 | 97,070,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **5,212,579,492.00** | **5,745,837,227.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,212,579,492.00** | **5,745,837,227.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,945,687,892.00** | **5,360,286,127.86** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,143,861,000.00 | 4,462,154,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,833,226,400.00 | 2,765,912,566.65 |
| 210102 | Нэмэгдэл | 1,144,820,100.00 | 1,548,370,389.35 |
| 210104 | Урамшуулал | 165,814,500.00 | 147,871,544.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 517,982,700.00 | 587,214,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 352,228,200.00 | 399,306,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 41,438,600.00 | 46,977,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 20,719,300.00 | 23,488,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 20,719,300.00 | 23,488,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 82,877,300.00 | 93,954,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 83,053,000.00 | 94,070,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,033,000.00 | 25,550,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 65,520,000.00 | 65,520,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 3,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,500,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 3,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 77,566,852.00 | 85,641,629.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,202,700.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 56,364,152.00 | 85,641,629.86 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 120,724,340.00 | 128,205,298.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 73,870,240.00 | 101,790,798.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 46,854,100.00 | 26,414,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **266,891,600.00** | **385,551,100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 266,891,600.00 | 385,551,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 266,891,600.00 | 385,551,100.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **102,906,308.00** | **(54,931,627.86)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **119,853,000.00** | **68,855,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **119,853,000.00** | **68,855,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 119,853,000.00 | 68,855,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 119,853,000.00 | 68,855,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(119,853,000.00)** | **(68,855,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (16,946,692.00) | (123,786,627.86) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 350,665,873.00 | 333,719,181.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 333,719,181.00 | 209,932,553.14 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 842,334,698.00 | 3,524,864,556.89 | (79,252,912.55) | 4,287,946,342.34 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **842,334,698.00** | **3,524,864,556.89** | **(79,252,912.55)** | 4,287,946,342.34 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 336,324,770.33 | 336,324,770.33 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **842,334,698.00** | **3,524,864,556.89** | **982,104,408.65** | 5,349,303,663.54 |
| D01 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **842,334,698.00** | **3,524,864,556.89** | **982,104,408.65** | 5,349,303,663.54 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 2,295,386.00 | 2,295,386.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **842,334,698.00** | **3,524,864,556.89** | **984,399,794.65** | 5,351,599,049.54 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (2,295,386.00) | - | (2,295,386.00) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (203,054,215.71) | (203,054,215.71) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **842,334,698.00** | **3,522,569,170.89** | **781,345,578.94** | 5,146,249,447.83 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,033,487,200.00** | **5,814,692,227.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,033,487,200.00** | **5,814,692,227.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,627,732,200.00 | 5,429,141,127.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,596,294,800.00 | 4,462,154,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,984,414,600.00 | 2,765,912,566.65 |
| 210102 | Нэмэгдэл | 1,429,175,000.00 | 1,548,370,389.35 |
| 210104 | Урамшуулал | 182,705,200.00 | 147,871,544.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 597,036,900.00 | 587,214,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 405,985,100.00 | 399,306,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 47,762,900.00 | 46,977,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 23,881,500.00 | 23,488,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 23,881,500.00 | 23,488,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 95,525,900.00 | 93,954,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 94,070,000.00 | 94,070,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,550,000.00 | 25,550,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,520,000.00 | 65,520,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 98,867,800.00 | 85,641,629.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 999,900.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 97,867,900.00 | 85,641,629.86 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 238,462,700.00 | 197,060,298.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 212,048,200.00 | 170,645,798.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 26,414,500.00 | 26,414,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 405,755,000.00 | 385,551,100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 405,755,000.00 | 385,551,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 405,755,000.00 | 385,551,100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,033,487,200.00 | 5,690,905,600.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 5,612,039,500.00 | 5,591,835,600.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 5,612,039,500.00 | 5,591,835,600.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 97,070,000.00 | 97,070,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 97,070,000.00 | 97,070,000.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 324,377,700.00 | 2,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,000,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 324,377,700.00 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 333,719,181.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 209,932,553.14 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 171.00 | 171.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 132.00 | 132.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30.00 | 30.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 8.00 | 8.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 430.5 сая төгрөгийн зөрчил илэрч 430.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 3.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй.

### 3.3 Зөвлөмж

Аудитын дүнгээр 430.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үдийн хоолны зардлын гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

1.1 Илрүүлэлт:

Сургуулийн үдийн хоолны 385.5 сая төгрөгийн төсвийг аж ахуйн нэгжээр гэрээгээр гүйцэтгүүлсэн бөгөөд тайланд онд үдийн хоолонд хамрагдсан өдөр бүрийн хүүхдийн ирцийн бүртгэлийг анги даасан багш, сургалтын менежер, эмч, хоол зүйч зэрэг албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулж, хянаж баталгаажуулан баримтжуулаагүй, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дараалаар гүйцэтгэнэ”, “журналд бичих”, 14.3.3 “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

*1.2 Өгсөн зөвлөмж*:

Сургуулийн үдийн үдийн хоолонд хамрагдсан хүүхдийн өдөр бүрийн ирцийн бүртгэлийг анги даасан багш, сургалтын менежер, эмч, хоол зүйч зэрэг албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтад тавих хяналтын сайжруулахыг зөвлөмж өгөв.

***2. Сургуулийн үдийн хоолны худалдан авах ажиллагаа, хэрэгжилттэй холбоотой асуудал***

2.1 Илрүүлэлт:

Сургууль нь үдийн хоолны төсвийг аж ахуйн нэгжээр гэрээгээр гүйцэтгүүлэхдээ сонгон шалгаруулалт явуулахгүйгээр шууд гэрээ байгуулсан байна. Тайлант онд гэрээ байгуулсан “Жана берекет” ХХК өөрийн хөрөнгөөр сургуулийн хоёр өрөөг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын өрөө болгон засварлаж, үдийн хоол нийлүүлж ажилласан боловч хэрэглэсэн цахилгааны төлбөрийн тооцоог хийж, төлүүлж аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ

бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж*:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх, үдийн хоол нийлүүлэгч байгууллагын хэрэглэсэн цахилгааны төлбөрийг сар бүр тооцоо хийж ажиллахыг зөвлөмж болгов.

***3.Өр төлбөртэй холбоотой асуудал***

3.1 Илрүүлэлт:

Сургууль нь тайлант онд багшийн туслахын 1, дизайн технологийн багшийн 1, шинээр 2 орон тоог бий болгож батлагдсан орон тооноос илүү ажиллуулсан нь оны эцэст ажиллагсадтай холбоотой 45.0 сая төгрөгийн өглөг гарахад нөлөөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Орон тооны хязгаарын жишиг нормативыг баримтлан орон тоо бүтцийг оновчтой тогтоох, илүү зардал гаргаж өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг бүрэн барагдуулж ажиллах;

***Дээрх зөвлөмж болон бусад шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.***

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах | Хууль, хяналтын байгууллага |

| | | | | | | | | | албан шаардлага | | д шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үдийн хоолны материалын тайлан гаргаж, тооцоо нийлдэггүй байна | 1 | 385,551.1 | | | | | 1 | 385,551.1 | | | | |
| Илүү орон тоо ажиллуулж ,өглөг үүсгэсэн | 1 | 45,000.9 | | | | | 1 | 45,000.9 | | | | |
| Үдийн хоолны худалдан авалт, хэрэгжилттэй холбоотой | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | 3 | 430,552.0 | | | | | **3** | **430,552.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |